

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын  
28-ны өдрийн А/799 дугаар захирамжийн I хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС БАЙГУУЛАГА, ИРГЭДИЙГ ШАГНАЖ,  
УРАМШУУЛАХ ЖУРАМ**

**Нэг: Нийтлэг үндэслэл**

Энэхүү журмын зорилго нь: Аймгийн Засаг даргын шагналаар байгууллага, иргэдийг шагнаж, урамшуулах шагналын төрөл, болзол, тавигдах шаардлагыг тодорхойлох, шагналд нэр дэвшүүлэх, холбогдох тодорхойлолтыг хүлээн авч судлах, уламжлах, шийдвэрлэх зэрэг шагнал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр: Шагналын төрөл**

- 2.1. Орхон аймгийн "Хүндэт тэмдэг"
- 2.2. Аймгийн "Оны тэргүүний ажилтан" өргөмжлөл
- 2.3. Орхон аймгийн Засаг даргын "Жуух бичиг"
- 2.4. Шилдэг бүтээн байгуулагч аж ахуйн нэгж
- 2.5. Нийгмийн салбарын шилдэг хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж
- 2.6. Шилдэг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж
- 2.7. Шилдэг жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж
- 2.8. Шилдэг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж
- 2.9. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага"
- 2.10. "Эрүүл ажлын байр" гэсэн төрөл байна.

**Гурав: Шагналын болзол, тавигдах шаардлага**

**3.1. Орхон аймгийн "Хүндэт тэмдэг"**

Аймгийн "Хүндэт тэмдэг" нь Орхон аймгийн Засаг даргаас олгох дээд шагнал бөгөөд шаардлагыг хангасан иргэнийг нэг удаа шагнана. Үүнд:

3.1.1. Орхон аймаг, Эрдэнэт хотын бүтээн байгуулалтанд хөдөлмөр, зүтгэлээ зориулж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байсан анхдагч ахмадууд, Орхон аймаг, Эрдэнэт хотод 20-иос доошгүй жил ажиллаж амьдарч, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой хувь нэмрээ оруулж байгаа иргэн,

3.1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлаг, биеийн тамир спорт, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, хууль, хяналт, уул уурхай, эрчим хүч, барилга, хот байгуулалт, байгаль орчин, нийтийн аж ахуйн үйлчилгээ, аялал жуулчлал, зам тээвэр, хөнгөн, хүнсний зэрэг салбарт онцгой амжилт гаргасан Орхон аймгийн иргэн,

3.1.3. Аймгийн харилцан ашигтай гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан гадаадын иргэнийг тус тус шагнана.

### 3.2. Аймгийн "Оны тэргүүний ажилтан"

3.2.1. Тухайн онд эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, аймгийн хэмжээнд ажлын амжилтаараа тэргүүлсэн Орхон аймгийн иргэнийг дараахь салбаруудаас нэр дэвшүүлэн шалгаруулж өргөмжлөл олгоно.

Үүнд:

1. Төр, захиргааны байгууллага
2. Хууль, хяналт, хүчний байгууллага
3. Эдийн засаг, банк, санхүүгийн салбар
4. Эрүүл мэндийн салбар
5. Боловсрол, шинжлэх ухааны салбар
6. Соёл, урлагийн салбар
7. Биеийн тамир, спортын салбар
8. Хэвлэл, мэдээллийн салбар
9. Шуудан, харилцаа холбооны салбар
10. Уул уурхайн салбар
11. Түлш, эрчим хүчний салбар
12. Барилга, хот байгуулалтын салбар
13. Зам, тээврийн салбар
14. Хөнгөн аж үйлдвэрийн салбар
15. Худалдаа, үйлчилгээний салбар
16. Хүнс, хөдөө аж ахуйн салбар
17. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар
18. Байгаль орчин, аялал жуулчлалын салбар
19. Иргэний нийгмийн байгууллага

3.2.2. "Оны тэргүүний ажилтан" өргөмжлөлөөр дээрх салбар тус бүрээс нэг хүнийг жилд нэг удаа шагнах ба тухайн оны эцэст аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

### 3.3. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"

3.3.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж, эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгаа иргэнийг шагнана.

3.3.2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан иргэнийг 2 жилээс доошгүй хугацаанд ажлын тодорхой амжилт гаргасан тохиолдолд дахин тодорхойлж болно.

### **Дөрөв: Шагналд нэр дэвшүүлэх**

4.1. Шагналд нэр дэвшсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын шагналын материал нь батлагдсан анкет /загварын дагуу/, ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай

тодорхойлолт, шагнуулах эрх бүхий албан тушаалтны албан бичиг, иргэний үнэмлэхийн хуулбар, хамт олны хурлын шийдвэрээс бүрдэнэ.

4.2. Шагналд нэр дэвшсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын үр дүн, гаргасан гавъяа зүтгэл, тухайн салбар, байгууллагын ажлын амжилтанд оруулсан хувь нэмэр нь тодорхой бөгөөд холбогдох судалгаа, тооцоогоор батлагдсан байна.

4.3. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар шагналд өөрийн санаачлагаар нэр дэвшүүлж болно.

#### **Тав. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч судлах, шийдвэрлэх**

5.1. Шагналын материалыг аймгийн Засаг даргын нэр дээр ирүүлэх бөгөөд аймгийн "Хүндэт тэмдэг", "Оны тэргүүний шагналтан", Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнуулахаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, шагналын материалыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, "Орхон аймгийн шилдэг аж ахуйн нэгж" шагналын материалыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага", "Эрүүл ажлын байр" шагналын материалыг Нийгмийн бодлогын хэлтэс тус тус хүлээн авч судлан, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох албан тушаалтнуудын саналыг авч, Засаг даргад танилцуулна.

5.2. Аймгийн Засаг дарга шагнах асуудлыг энэхүү журмыг үндэслэн захирамж гарган шийдвэрлэх ба дээрх шагналыг бэлтгэх, гардуулах асуудлыг холбогдох хэлтсүүд хариуцна.

5.3. Шагналын материалыг тухайн тэмдэглэлт өдрөөс 7-10 хоногийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн байх шаардлагатай.

5.4. Шагнагдсан иргэдийн судалгааг Засаг даргын Тамгын газрын шагналын мэдээллийн санд хадгална.

#### **Зургаа. Шагналыг дагалдах мөнгөн урамшууллын хэмжээ:**

6.1. Орхон аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнагдсан иргэнд 100,000 төгрөг олгох ба уг дагалдах мөнгөн урамшууллыг тухайн иргэний ажиллаж буй буюу тодорхойлсон байгууллага нь, бусад тохиолдолд аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын сангаас тус тус олгоно. "Хүндэт тэмдэг"-ээр шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.

6.2. Аймгийн "Оны тэргүүний ажилтан" өргөмжлөл, 100,000 төгрөг

6.3. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-т 50,000 төгрөг

6.4. Шилдэг бүтээн байгуулагч аж ахуйн нэгж – гэрчилгээ, цом, 3,000,000 төгрөг

6.5. Нийгмийн салбарын шилдэг хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж – гэрчилгээ, цом, 3,000,000 төгрөг

6.6. Шилдэг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж – гэрчилгээ, цом, 3,000,000 төгрөг

6.7. Шилдэг жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж – гэрчилгээ, цом, 3,000,000 төгрөг

6.8. Шилдэг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж – гэрчилгээ, цом, 3,000,000 төгрөг

6.9. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" шагналд:

6.9.1. Гэрчилгээ, 1-р зэрэг - 500,000 төгрөг

6.9.2. Гэрчилгээ, 2-р зэрэг - 400,000 төгрөг

6.9.3. Гэрчилгээ, 3-р зэрэг - 300,000 төгрөг

6.10. "Эрүүл ажлын байр" шагналд:

6.10.1. Гэрчилгээ, 1-р зэрэг - 300,000 төгрөг

6.10.2. Гэрчилгээ, 2-р зэрэг - 200,000 төгрөг

6.10.3. Гэрчилгээ, 3-р зэрэг - 100,000 төгрөгийн урамшууллыг батлагдсан шагналын сангаас тус тус олгоно.

**Долоо. Аймгийн "Хүндэт тэмдэг" түүний үнэмлэхийг нөхөн болон сольж олгох**

7.1. Орхон аймгийн "Хүндэт тэмдэг" дагалдах үнэмлэхийг ямар нэг шалтгаанаар үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг эх, төрсөн ах, эгч, дүү нь тухайн нөхцөл шалтгааныг тодорхой бичсэн өргөдлөө, дээрх зүйлсийн үнийг тушаасан баримт, гэмтсэн зүйлийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

7.2. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс уг өргөдлийг хянан үзэж нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

7.3. Бусад шагналыг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд нөхөн олгохгүй.